

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 тоот тушаалын
6 дугаар хавсралт

Дотуур байрын багшийн хөгжил хариуцсан арга зүйч, мэргэжилтэн, Дүгэрчулуун Сайнзаяа

2025 ОНЫ ХАГАС ЖИЛ-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
1	2	3	4	5	6	7	
1.1. Багш, ажилтны мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулж, мэргэжлийн тасралтгүй хөгжлийг хангахад дэмжлэг үзүүлэх.							
1	Ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын дотуур байрын орчин, үйл ажиллагаанд зөвлөн туслах, мониторинг хийх.	Зөвлөн тусалж мониторинг хийсэн дотуур байрын тоо	21	5 дотуур байр, 100%	1. Хүүхдийн эрх, Хүүхэд хамгааллын тухай хууль, Стандарт хэмжил зүйн газрын даргын 2019 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн С/40 дүгээр тушаалаар батлагдсан “Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дотуур байрын орчин, үйлчилгээ Ерөнхий шаардлага MNS 6781:2019” стандартын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Баянзүрх дүүргийн Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны орчинд үзүүлэх хүүхэд хамгааллын үйлчилгээний төлөвлөлт, хэрэгжилт, дотуур байрны орчин стандартын дагуу байгаа эсэх, хүүхдийн эрх	2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор 2025 оны 05 дугаар сарын 26-29-ний өдрүүдэд БЗД-ийн дотуур байруудад ажиллалаа. 2. Нийслэлийн ерөнхий боловсролын 29, 116, 121, 74 дүгээр сургууль болон Өмнөговь аймгийн Даланзадгад сумын ерөнхий боловсролын 1, 4-р сургуулийн дотуур байрны орчин нөхцөл, үйл ажиллагаатай танилцан сургуулийн удирдлага, дотуур байрын багш нарт Хүүхэд хамгаалаллын чиглэлээр болон хүүхдийн орчин нөхцлийг сайжруулах тэднийг хөгжүүлэх чиглэл дээр нь зөвлөн тусалж арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллалаа.		
2	Сургалтын байгууллагын “Мэргэжлийн хөгжлийн бүлэг”-ийн үйл ажиллагаанд зөвлөн туслах, үндэсний хэмжээнд тайлант өдөрлөг зохион байгуулж, МХБ-ийн сайн туршлагын сан бүрдүүлнэ. (МУЗГҮАХ-2.2.3.1)	Зөвлөн тусалсан МХБ-ийн тоо, МХБ-ийн сайн туршлагын тоо	0	116 (МХБ-ийн тоо), 25 (сайн туршлагын тоо)	Хүүхдийн цэцэрлэг, Ерөнхий боловсролын сургуулийн багш ажилтны мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагааны журмын хэрэгжилт, түүний нөхцөл байдлыг илрүүлэх судалгааны ажлыг зохион байгуулалтаар хангаж ажиллаж байна. “Хүүхдийн цэцэрлэг, Ерөнхий боловсролын сургуулийн багш, удирдах ажилтны мэргэжил дээшлүүлэх журам” – ын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх ажлын	2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	90%

					чиглэл Зорилго: Мэргэжлийн багш нарын бүлгийн үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийх/нөхцөл байдлыг илрүүлэх, зөвлөн туслах Хэрэгжүүлэх үйл ажиллагаа: 1. Сургуулийн захиралтай ярилцлага хийх 2. Багшийн хөгжлийн менежертэй ярилцлага хийх 3. Багшийн хөгжлийн төвийн нэгдсэн төлөвлөгөөтэй танилцах/Мэргэжлийн багш нарын бүлгийн үйл ажиллагаа тусгагдсан байдал/ 4. Мэргэжлийн багш нарын бүлэг /Суралцахуйд суурилсан - тэгш хамруулан сургах арга зүй, хүүхэд хөгжил, хамгааллын чиглэлээр байгуулагдсан МББ/-ийн мэдээлэл илрүүлэх 5. Мэргэжлийн багш нарын бүлэг /Судлагдахууны чиглэлээр байгуулагдсан МББ/-ийн мэдээлэл илрүүлэх 6. Сайн туршлагын мэдээлэл илрүүлэх – загвар боловсруулах		
3	СӨБ болон ЕБС-ийн багш, ажилтны мэргэжлийн хөгжлийг дэмжих сургалтаас бусад олон талт (эрдэм шинжилгээний болон онол практикийн бага хурал, зөвлөгөөн,	Сургалт, үйл ажиллагааны батлагдсан хөтөлбөр, удирдамж, тайлан, оролцогчдын тоо	Сургалт-8, оролцогч-1211	Сургалтаас бусад үйл ажиллагаа 3-аас доошгүй зохион байгуулсан байна. 100%	- Дотуур байрын багш нарын албан тушаалын тодорхойлолт шинэчлэн батлахтай холбогдуулан албан тушаалд тавигдах нийтлэг шаардлагыг шинэчлэх, сайжруулах төсөлд багш нарын саналыг	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р	100%

	хэлэлцүүлэг, түншлэл, хамтын үйл ажиллагаа) ажлыг зохион байгуулах.			нэгтгэн орууллаа, ингэхдээ дотуур байрны асуудал хариуцсан мэргэжилтнүүдтэй 1 удаа цахим хурал, багш нартай 2 удаа цахим хурал хийж ажиллалаа. Дотуур байрын багш нарын албан тушаалын нийтлэг шаардлага шинэчлэгдсэнээр багш нарын үүрэг, хариуцлагыг илүү тодорхой болгох, ажлын нөхцөлийг сайжруулах боломжтой болж байгаа юм. - Дотуур байрын хүүхдийн хэрэгцээнд нийцэхгүй байгаа болон шаардлагатай тоног төхөөрөмж, эд материалын судалгаа гаргаж нэгтгэн ажиллалаа. тус судалгааг дэлгэрэнгүй гаргаснаар дотуур байрны орчин нөхцөлийг сайжруулахад шаардлагатай болон шаардлага хангахгүй байгаа эд материал, тоног төхөөрөмжийн тоо нэгтгэл тодорхой болж байгаа юм. - Боловсролын яамнаас зохион байгуулсан "Эрүүл аюулгүй сургууль" арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах болон "Хүүхдэд ээлтэй дотуур байр"-ны 2025-2028 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төслийн	сар, 11-р сар, 12-р сар	
--	---	--	--	---	-------------------------	--

					танилцуулга уулзалтад оролцож санал бодлоо илэрхийлж ойлголтоо нэгтгэн шийдэлд хүрч ажиллалаа. - Бүх нийт боловсролын төлөө иргэний нийгмийн үндэсний эвсэл Монгол улсын их хурлын Хүний эрхийн дэд хороотой хамтран зохион байгуулсан "Дотуур байр-2.0" үндэсний зөвлөгөөнд хамтран ажиллалаа. Тус зөвлөгөөнд УИХ-ын гишүүн Эрдэнэболд, Баасанжаргал, Хэрлэн, ХҮК-ын гишүүн Хунан, БЕГ-ын дарга Т.Ням-Очир, ГБХНХЯ-ын газрын дарга Цогтбаатар болон бусад албаны хүмүүс оролцож Дотуур байрны хүүхдийн асран хамгааллын асуудалд оролцогч талуудын ойлголтыг нэгтгэх, бодлогод дотуур байрыг "Дахин загварчлах" асуудлыг хэлэлцэн, цаашид дотуур байран дахь хүүхэд хамгааллын тогтолцоог сайжруулахын тулд хүүхдийн асрамж халамжийн асуудлыг цогцоор нь өөрчлөх бодлогын шийдлийг боловсруулах, салбар хоорондын зөвшилцөлд хүрэхийг зорьсон. Хавсралт: 14 файл		
--	--	--	--	--	--	--	--

4	Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрын багш, ажилтнуудыг чадавхжуулах сургалтаас бусад олон талт үйл ажиллагааг зохион байгуулж, зөвлөн тусална.	хамрагдсан хүний тоо, гүйцэтгэлийн хувь	100	100%	- Дотуур байрын багш нарын албан тушаалын тодорхойлолт шинэчлэн батлахтай холбогдуулан албан тушаалд тавигдах нийтлэг шаардлагыг шинэчлэх, сайжруулах төсөлд багш нарын саналыг нэгтгэн орууллаа, ингэхдээ дотуур байрны асуудал хариуцсан мэргэжилтнүүдтэй 1 удаа цахим хурал, багш нартай 2 удаа цахим хурал хийж ажиллалаа. Дотуур байрын багш нарын албан тушаалын нийтлэг шаардлага шинэчлэгдсэнээр багш нарын үүрэг, хариуцлагыг илүү тодорхой болгох, ажлын нөхцөлийг сайжруулах боломжтой болж байгаа юм. - Дотуур байрын хүүхдийн хэрэгцээнд нийцэхгүй байгаа болон шаардлагатай тоног төхөөрөмж, эд материалын судалгаа гаргаж нэгтгэн ажиллалаа. тус судалгааг дэлгэрэнгүй гаргаснаар дотуур байрны орчин нөхцөлийг сайжруулахад шаардлагатай болон шаардлага хангахгүй байгаа эд материал, тоног төхөөрөмжийн тоо нэгтгэл тодорхой болж байгаа юм. -	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%
---	--	---	-----	------	---	--	------

					Боловсролын яамнаас зохион байгуулсан "Эрүүл аюулгүй сургууль" арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах болон "Хүүхдэд ээлтэй дотуур байр"-ны 2025-2028 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийн танилцуулга уулзалтад оролцож санал бодлоо илэрхийлж ойлголтоо нэгтгэн шийдэлд хүрч ажиллалаа.		
5	Дотуур байрын багш нарт сард нэг удаа цахим уулзалт хийх	Хамрагдсан багшийн тоо	10 удаагийн сургалтад давхсан тоогоор 5000 гаруй багш хамрагдсан	715 багш, 80-90%	Дотуур байрын багш нарыг цаг үеийн мэдээллээр хангах, харилцан мэдээ мэдээлэл солилцох зорилгоор 5 удаагийн цахим уулзалт зохион байгуулж хүүхэд хөгжил, хамгаалал, эрүүл мэнд зэрэг агуулгын хүрээнд мэдээлэл өгч тэдний санал бодлыг сонсож цаашид дотуур байрын орчин нөхцлийг сайжруулах чиглэлээ тодорхойлж ажиллалаа. Хавсралт: 3 файл	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%
6	Дотуур байрын асуудал хариуцсан мэргэжилтнүүдтэй улиралд 1 удаа цахим уулзалт хийх	Уулзалтад хамрагдсан мэргэжилтнүүдийн тоо	4 удаагийн уулзалтад 90 хувьтай хамрагдсан.	25 мэргэжилтэн, 100%	Нийслэл болон 21 аймгийн Боловсролын газрын Дотуур байрны асуудал хариуцсан мэргэжилтнүүдтэй жилд 4 удаагийн цахим уулзалт хийнэ гэж төлөвлөсөн байдаг бөгөөд төлөвлөгөөний дагуу 2	2-р сар, 5-р сар, 9-р сар, 12-р сар	100%

					удаагийн уулзалт хийлээ. Цахим уулзалтаар дотуур байрын багшийн албан тушаалын тодорхойлолтын нийтлэг шаардлага шинэчлэн батлахтай холбогдуулан санал солилцох, дотуур байрны орчин нөхцөл, үйл ажиллагааг сайжруулахад орон нутаг юу анхаарах, дотуур байрын багшийг норм нормативын дагуу ажиллуулах зэрэг асуудлын хүрээнд санал бодлоо солилцож ойлголтоо нэгтгэлээ. Мөн 2024-2025 оны хичээлийн жилийн дотуур байрны тайлан хэлэлцэх, дотуур байрны ололт амжилт, тэргүүн туршлагыг бусадтай хуваалцах, цаашид анхаарах асуудлаа тодорхойлох зорилгоор аймаг, нийслэлийн дотуур байрны асуудал хариуцсан мэргэжилтэн бүрийн тайлан сонсож дүгнэлт хийлээ. Хавсралт: 3 файл		
7	Хамтын ажиллагаа, санамж бичгийн хүрээнд гадаад улсын Боловсролын газартай туршлага солилцох үйл ажиллагаа зохион байгуулах.	Туршлага солилцсон албан хаагчийн тоо, үр дүн	6 албан хаагч хамрагдсан.	-	Хоёр дугаар хагас жилд хэрэгжинэ.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р	0%

						сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	
8	Багшийн хөгжлийг дэмжих платформд суурилсан сургалтын бүрдүүлэх.	Платформд байршуулсан шаардлага хангасан цахим сургалтын тоо, чанар	0	Платформын хөгжүүлэлт хийж, 12 модул сургалтын сан бүрдүүлсэн байна, 90%	Сургалтын байгууллагын багш, удирдах ажилтан өөрсдийн хөгжлийн хэрэгцээнд үндэслэн цаг хугацаа, орон зайнаас үл хамааран суралцах боломж бий болгох зорилт тавин ажиллаж байна.Багшийн хөгжлийг дэмжих Bagsh.edu.mn платформ суурилан суралцах боломжтой болж байна.Боловсролын ерөнхий газраас 2023-2024 онд зохион байгуулсан модуль сургалтын үр дүнгийн судалгаа, мониторингоос багш нараас хамгийн өндөр үнэлгээ авсан 12 модулийг сонгож, боловсруулсан багтай гэрээ байгуулан БЕГ-ын өмчид авсан.Манай байгууллага гэрээний дагуу тус 12 модулийг ашиглан сургалт зохион байгуулах эрхтэй. Багшийн хөгжлийн Bagsh.edu.mn платформд 12 модулийг байршуулсан бөгөөд багш нар сонголтоороо үнэ төлбөргүй судалж, амжилттай төгсвөл батламж авах боломжийг бүрдүүлсэн.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	95%

3.1. Нэгжийн үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг мөрдөн ажиллах

9	Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулах, тайлагнах, дүгнүүлэх ажлыг хугацаанд нь чанартай гүйцэтгэх.	Гүйцэтгэлийн хувь	98 хувь	Гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж, системд оруулна, батлуулна, хэрэгжилтийг хувь ханган ажиллана, 100%	Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг 2 зорилтын хүрээнд хүрээнд 13 арга хэмжээ төлөвлөн батлуулсан бөгөөд гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу ажлаа гүйцэтгэж тайлан мэдээгээ тухай бүр бичиж дүгнүүлж байна. Хавсралт: 1 файл	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%
10	Ерөнхий газрын даргын шуурхай хурал, даргын зөвлөлийн хурлаас өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангаж ажиллах	Биелэлт /хувь/	100%	100%	1. Байгууллагын удирдлага нэгжийн даргаас өгсөн үүрэг даалгаврыг цаг тухай бүр чанартай биелүүлж ажиллаж байна. Тухайлбал Монгол Улсын Их Хурлын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооноос 2025 оны 01-р сарын 09-ний өдөр зохион байгуулсан төвийн бүсийн ерөнхий боловсролын болон сургуулийн өмнөх боловсролын байгууллагын удирдах ажилтнуудын сургалт, зөвлөгөөн зохион байгуулах ажлын хэсэгт ажиллан байгууллагуудтай гэрээ байгуулах, сургалтын бэлтгэл ажил хангах, дүгнэлт хаалтын үйл ажиллагааны бэлтгэл ажил хангахад бүхий л бололцоогоороо оролцож хангалттай дүгнүүлсэн.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					2.Нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн багшийн хөгжил хариуцсан сургалтын менежерүүдийг чадавхжуулах сургалт зохион байгуулах ажлын хэсэгт ажиллалаа. Тус ажлын хүрээнд 45 хүнтэй анги хариуцаж сургалтын бэлтгэл ажил хангах, сургалт зохион байгуулагдах хүртэл үйл ажиллагааг хариуцан ажилласан. 3. ЕБС, СӨБ-ын багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдах багш нарын тоо гаргах нэгтгэл хийх, зөвлөх багш нартай гэрээ байгуулах ажлыг гүйцэтгэсэн. Мөн Ерөнхий боловсролын сургуульд 5, 10, 15, 20 дахь жилдээ ажиллаж байгаа багш нарт мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалт зохион байгуулах ажлын хүрээнд Нийслэлийн ерөнхий боловсролын 52-р сургууль болон Ховд, Баян-Өлгий аймгийн багш нарт сургалт явууллаа. 4. Мэргэжлийн болон техникийн сургалтын байгууллагын мэргэжлийн зэрэг ахиулахаар бүрдүүлсэн математикийн багш нарын 8 материалд газрын мэргэжилтэн Д.Отгонтуяатай хамтран хянаж, дүгнэлт гаргаж		
--	--	--	--	--	---	--	--

					ажиллалаа. Хавсралт: 5 файл		
11	Архив, албан хэрэг хөтлөлтийн журмыг хэрэгжүүлж, эрхлэх асуудлын чиг үүрэгт хамаарах мэдээ, мэдээлэл, тайлан, холбогдох материалыг хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу архивын нэгж болгон хадгалуулах	Биелэлт /хувь/	100%	100%	Архив, албан хэрэг хөтлөлтийн журмыг хэрэгжүүлж, эрхлэх асуудлын чиг үүрэгт хамаарах мэдээ, мэдээлэл, тайлан, холбогдох материалыг нэгжийн архивлах материалд бүрдүүлэн өгсөн ба өөрөө нэг дэвтэр материал үдэж хүлээлгэж өгсөн.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 11-р сар, 12-р сар	100%
12	Авлигын эсрэг хууль, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх	Биелэлт /хувь/	100%	100%	Авлигын эсрэг хууль, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан чиг үүргийг өдөр тутамд хэрэгжүүлж ажиллаж байна.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

№	Үүрэг даалгавар	Өгсөн субъект	Биелэлт
1	2	3	4

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь	Хүрэх	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн,	Биелэлтийн

			түвшин	түвшин		дууссан хугаца	хувь
	1	2	3	4	5	6	7
4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх							
1	Төр болон ТББ-аас хүүхдийн хөгжил хамгаалал, багшийн мэргэжлийн хөгжлийн чиглэлээр зохион байгуулах сургалт, зөвлөгөөн, онол практикийн бага хурал болон бусад үйл ажиллагаанд товлогдсон хугацаанд оролцох, хамтран ажиллах	Оролцсон сургалт, зөвлөгөөний тоо	100 хувь оролцсон.	100%	1. УИХ-ын Хүний эрхийн дэд хороо, Боловсролын ерөнхий газар, “Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвсэл, “Хил хязгааргүй хуульчид” НҮТББ, Өмгөөллийн “Легал гайд” хуулийн фирм болон “GOGO” мэдээний сайт нар хамтран 2025 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр “Дотуур байр 2.0” сэдвийн хүрээнд үндэсний бодлогын зөвлөгөөн зохион байгууллаа. Тус зөвлөгөөний зохион байгуулалтад оролцох, шаардлагатай мэдээ мэдээллээр хангах, зөвлөмжид тусгах санал боловсруулж хамтран ажилласан. 2. НҮБ-ын Хүүхдийн сангийн тайлангийн хуралд оролцож цаашид хамтран ажиллах тал дээр санал бодлоо солилцож хамтран ажиллаж байна. 3. Азийн хөгжлийн банкнаас зохион байгуулж буй "Монгол улсад жендэрт суурилсан хүчирхийллийн урьдчилан сэргийлэх болон хариу арга хэмжээ авах" төсөлд хамтран ажиллаж байна. Тухайлбал төслийн арга хэмжээний хүрээнд 4 дотуур байрын их засвар болон үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх учир шалгуур үзүүлэл, зорилтыг хангасан дотуур байрын мэдээ	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					мэдээлэл гаргаж нэгтгэх болон төслийг хэрэгжих хүртэлх хугацаанд төслийн багтай хамтран ажиллаж байна. 4. Бусад төр болон төрийн бус байгууллагаас явуулсан сургалт, уулзалтад хамрагдаж хамтран ажиллаж байна. Хавсралт: 15 файл		
2	Байгууллагын хүний нөөцийг чадавхжуулах дотоодын сургалтуудад хамрагдах	Хамрагдсан сургалтын тоо	95 хувь хамрагдсан.	100%	Байгууллагаас зохион байгуулсан Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн танилцуулга сургалтад хамрагдлаа. Монгол Улсын Их Хурлын 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн хуралдаанаар Нийгмийн даатгалын багц хуулийг батлан, 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 37 дугаар зүйлийн 37.14.8 дахь заалтад "Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг ажил олгогч, даатгуулагч, олон нийтэд таниулах, мэдээллээр хангах" гэж заасны дагуу Нийгмийн даатгалын багц хуулийн сургалтыг Боловсролын ерөнхий газрын албан хаагчдад НДЕГ-ын сургалтын хэлтсийн дарга С.Ундармаа, сургалт хариуцсан мэргэжилтэн Б.Цэрэнчимэд нар зохион байгууллаа. Сургалтад хамрагдсанаар нийгмийн даатгалтай холбоотой тулгамдсан асуудал, кейсээ асууж тодруулан мэдлэг, ойлголтоо нэмэгдүүллээ.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					Хавсралт: 5 файл		
3	Ажил үүргийн холбогдолтой шинээр батлагдсан хууль, тогтоомж, тогтоол, шийдвэрийг судлах	Уншиж судалсан хууль, тогтоомж, тогтоолын тоо	95 хувь судалсан.	100%	1. Дотуур байрын багшийн албан тушаалын тодорхойлолтын нийтлэг шаардлагыг шинэчлэн баталсан Боловсролын сайдын 2025 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн А/106 дугаар тушаалын хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2. Эрүүл, аюулгүй сургууль арга хэмжээ, хэрэгжүүлэх төлөвлөгөө /2025-2028/-г хэрэгжүүлэхэд хамтран ажиллаж байна. 3. Боловсролын Сайдын 2024 оны 12-р сарын 31-ний өдрийн А/279 дугаар тушаалын хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 4. Боловсролын сайдын 2025 оны 01 дүгээр сарын 22 ны А/25 тоот тушаалаар баталсан Хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилтны мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагааны журмыг судлан хэрэгжүүлж байна. 5. Бусад ажил үүргийн холбогдолтой шинээр батлагдсан хууль, тогтоомж, тогтоол, шийдвэрийг судалж хэрэгжүүлж ажиллаж байна. 6. Монгол хэлний тухай хуульд төрийн болон орон нутгийн өөрөө удирдах байгууллага 2025 оны нэгдүгээр сарын 1-нээс албан хэргээ кирилл, үндэсний хос бичгээр хөтлөн явуулна гэж заасан. Энэ хүрээнд монгол бичгийн мэдлэг чадвараа ахиулж бичгээ хэвээ сайжруулах, уншихь	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					бичих чадвараа сайжруулахад анхааран ажиллаж байна. Мөн англи хэлний мэдлэгээ дээшлүүлж өдөр тутамдаа хэрэгжүүлж ажиллаж байна. Хавсралт: 2 файл		
--	--	--	--	--	---	--	--

ТАЙЛАН ГАРГАСАН:

Дотуур байрын багшийн хөгжил хариуцсан арга зүйч, мэргэжилтэн, Дүгэрчулуун Сайнзаяа /...../

Огноо: